

Ажилтан ажилчдаа сургаж мэргэшүүлэх чиглэлээр:

Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтанд тус тус хамрагдлаа.

№	Хамрагдсан сургалт	Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс	Хугацаа
1	Сэжүн Хагда “Солонгос хэлний жилийн сургалт	Б.Батчимэг захирлын туслах шуурхай асуудал хариуцсан ажилтан Б.Удвалцэцэг уран бичлэгийн багш Б.Мөнхцэцэг гадаад харилцааны ажилтан	2018.11 сараас 2019.05 сар
2	Нийслэлийн архивын сургалт	С.Баярмаа- архив бичиг хэргийн ажилтан	2019.05 сар
3	Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам Мэргэжлийн боловсрол сургалтын Улаанбаатар бүсийн арга зүйн төвийн Мэргэжлийн сургалтын байгууллагын багш нарт зориулсан “Багшлах эрхийн сургах зүйн чадамж эзэмшүүлэх	Б.Булгантуяа- Хүүхэлдэй бэлэг дурсгалын багш Т.Гэрэлмаа – Монгол үндэсний хувцас загварын багш	2019. 04.01-06.01
1	2	3	4
	мэргэшлийн гэрчилгээтэй 3 сарын сургалт		
4	Нийслэлийн боловсролын газраас зохион байгуулдаг Нийгмийн ажилтаны сургалт	Б.Энхцэцэг –Нийгмийн ажилтан	2019.04 сар
5	Монгол Улсын Багшийн Их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуулийн боловсролын удирдлагын магистрын зэрэг олгох сургалт	Л.Атар – хүний нөөцийн ажилтан	2019-2020 05.20-06.25
6	Торгоны зам чин сэтгэлийн харилцааны хүрээнд “Хайрын түгээлт нөхөн сэргээх” Компютерийн сургалт	С.Байгалмаа-мэдээлэл технологийн ажилтан С.Батчимэг- захирлын туслах шуурхай асуудал хариуцсан ажилтан С.Баярмаа- архив бичиг хэргийн ажилтан Б.Батгэрэл- сургалтын менежер	2019.10.23.
7	Сүхбаатар дүүргийн Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн хэлтэс Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 8 цагийн сургалт, Сертификат	Б.Энхцэцэг –Нийгмийн ажилтан	2019.10.29.

**2019 ОНД БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЧДАД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТЫН
ТОВЬЁГ**

2019 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

№	Сургалт, ажлын нэр	Сургалт, ажлын хэлбэр хэн хаанаас өгсөн	Он сар өдөр	Хамрагдсан хүний тоо
1	2	3	4	5
1	Ажилчдад гамшгийн бэлэн байдлын талаар мэдээлэх сургалт	Аж ахуй хариуцсан ажилтан Б.Ганбаатар	03.20.	45 ажилчид
2	Бүжгийн сургалт	Moondance хамтлагийн гишүүн	03.28	56 ажилчид
3	Ажилчдад хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл жендерийн эрх тэгш байдлын талаар сургалт	СБДГБЗХХэлтсийн мэргэжилтэн н.Алтантүлхүүр	03.29	35 ажилчид
4	Ажилчдад Цусны даралт ихдэх өвчнөөс сэргийлье” дарлт бууруулах цэгэн иллэг” сургалт	СБ Дүүргийн Сайн наран өрхийн эмнэлэгийн эрүүл мэндийн нийгмийн ажилтан н.Цолмон	04.12.	26 ажилчид
5	Ажилчдад стрессгүй аж төрөх, хамт олны эв нэгдэл, эрүүл амьдралын дадал хэвшил” сургалт	Сэтгэл судлаач Ж.Отгонбаяр	05.03.	53 ажилчид
6	Ажилчдад шинэ гарсан хуль тогтоомжийн талаар сургалт	Хуулийн зөвлөх Лхамсүрэн	05.28.	40 ажилчид
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх нь сургалт	Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Нийслэлийн Нийгмийн халамжийн газар	06.19.	Хүний нөөцийн ажилтан Л.Атар, нийгмийн ажилтан Б.Энхцэцэг
8	Багш ажилчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор комьютерийн хэрэглээний программийн сургалт	Интерактив Би Ай ХХК ний мэргэжилтэн Н.Бат-Эрдэнэ оффис хэрэглээний WORD, EXCEL, PHOTOSHOP программ болон компьютер ашиглалт түүний талаарх	09.09, 10,11	44 ажилчид
9	“Зөв зохистой хооллолт” сургалт	Self Medic Mongolia эмнэлгийн менежер, эмч	09.20.	53 ажилчид
10	Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах 2 дах удаагийн сургалт	НХГХГ, СБДХГХХ	10.29.	Нийгмийн ажилтан Б.Энхцэцэг

1	2	3	4	5
11	Ажилчдад багийн ажиллагаа, аз жаргал, хариуцлага” сургалт	“Хамтдаа бүтээх Монголын мөрөөдөл НҮТББ” ажилтан О.Урангоо	11.08.	25 ажилчид

НЭГТГЭН БИЧСЭН
НИЙГМИЙН АЖИЛТАН


Б.ЭНХЦЭЦЭГ

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН АЖИЛЧДАД
“БАГИЙН АЖИЛЛАГАА, АЗ ЖАРГАЛ ХАРИУЦЛАГА” СЭДВЭЭР ЯВУУЛСАН
СУРГАЛТЫН ТАЙЛАН

2019 оны 11 дүгээр сарын 08

Улаанбаатар хот

Хамт олны харилцаа хандлага, бие биенээ хүндэтгэх, хувь хүний соёл, аз жаргалын талаар “БАГИЙН АЖИЛЛАГАА” сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 08-ний өдөр 10.40-12.20 цаг хүртэл зохион байгууллаа. Уг сургалтыг “Хамтдаа бүтээх Монголын Мөрөөдөл НҮТББ”-ын ажилтан О.Урангоо явууллаа. Сургалтаар хамт олон гэдэг нь баг, хайр юм. Маш их хоорондоо ярилцах, бие биендээ хүндэтгэлтэй хандах хэрэгтэй талаар ярилцлаа. Хамт олны хандлагын талаар бие биенийхээ сайн талыг сэвүүр дээр бичих “Дэвүүр” тоглоомыг явууллаа. Багийн ажиллагаа сургалтад 25 ажилчид оролцлоо. Маш сонирхолтой сайхан сургалт боллоо.



ТАЙЛАН БИЧСЭН
НИЙГМИЙН АЖИЛТАН


Б.ЭНХЦЭЦЭГ

ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮДИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ 2 ДАХ УДААГИЙН СУРГАЛТ





2019 оны 10 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн Хүүхэд гэр бүл хөгжлийн газартай хамтран Сүхбаатар дүүргийн хороонуудын нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч, сургуулийн нийгмийн ажилтнуудад хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг 2019 оны 10 дугаар сарын 29 ний 10.00-17.00 цагт зохион байгууллаа. Уг сургалтад 6 хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нартай хамт оролцлоо.



Хамтарсан багийн ажиллах эрх зүйн орчин, чиг үүрэг, хүүхэд хамгааллын хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж, нэг цэгийн үйлчилгээний төвийн тухай мэргэжилтнүүд сургалт явуулж, зөвлөгөө, зөвлөмж өглөө. Мөн өгсөн сургалтаа батжуулж багаар ажиллуулж, сертификат гардууллаа.



ТАЙЛАН БИЧСЭН
НИЙГМИЙН АЖИЛТАН

Б.ЭНХЦЭЦЭГ

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН БАГШ АЛБАН ХААГЧДАД
“СТРЕССГҮЙ АЖ ТӨРӨХ, ХАМТ ОЛНЫ ЭВ НЭГДЭЛ” СЭДВЭЭР ЯВУУЛСАН
СУРГАЛТЫН ТАЙЛАН

2019 оны 05 дугаар сарын 02

Улаанбаатар хот

2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Сэтгэл судлаач багш н.Отгонбаярыг урьж Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн багш, албан хаагчдад “Стрессгүй аж төрөх, хамт олны эв нэгдэл” сэдэвт сургалт явууллаа. Тус сургалтад нийт ажилтнуудын 80% нь идэвхтэй оролцлоо.



БОЛОВСРУУЛСАН:
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Б.БАТГЭРЭЛ

"ЗӨВ ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТ"

2019 оны 09 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

Self Medic Mongolia эмнэлгийн хамт олон нь Японы цахилгаан эмчилгээгээр бүх насны хүнийг оншилж, эмчилдэг байгууллага юм. "Зөв зохистой хооллолт" сэдвээр сургалт зохион байгууллаа.

Нийт ажилчдад зөв хооллолтын талаар зөвлөмж өгсөн. Нийт 53 ажилчид эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдлаа.



ТАЙЛАН БИЧСЭН
ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

Л.АТАР

КОМПЬЮТЕРИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАММИЙН СУРГАЛТЫН ТАЙЛАН

2019 оны 09 дүгээр сарын 13

Улаанбаатар хот

Багш ажилчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор компьютерийн хэрэглээний программийн сургалт зохион байгуулна. Сургалтыг Интерактив Би Ай ХХК –ний мэргэжилтэн Н.Бат-Эрдэнэ оффис хэрэглээний WORD, EXCEL, PHOTOSHOP программ болон компьютер ашиглалт түүний талаарх мэдлэг олголоо. Сургалт 2019.09.09-09.11-ны 10:00-12:00 цагийн хооронд 3 удаа хичээллэж нийт 52 ажилтан хамрагдсан.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ НЬ СУРГАЛТЫН ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Нийслэлийн Нийгмийн халамжийн газар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэмжих нийслэлийн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан дэд бүтэц, орчны хүртээмжийн байдалд үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлсэн.

2019.06.19-ний өдрийн 10:00-14:00 цагт Үнэлгээний талаарх “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх нь” сургалтанд хүний нөөцийн ажилтан Л.Атар, нийгмийн ажилтан Б.Энхцэцэг нар хамрагдав. Уг сургалтанд нутгийн захиргааны байгууллагуудын дэд бүтэц, орчны хүртээмжид хийсэн үнэлгээний талаар Нийслэлийн нийгмийн халамжийн газрын мэргэжилтэн Х.Дашхорлоо, иргэний зориулалттай барилгад тавигдах, үндсэн шаардлагууд /шат, налуу, зам, ариун цэврийн өрөө / талаар мэдээлэл НМХГазрын хяналтын улсын байцаагч С.Одсүрэн, явган хүний зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар, төлөвлөлтийн талаар мэдээллийг НМХГазрын авто замын ахлах байцаагч Дуламрагчаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандартын талаар Түгээмэл хөгжлийн төвийн ажилтан П.Дашдаваа нар сургалт явууллаа.

Сургалтын зургийг хавсаргав.



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН БАГШ АЛБАН ХААГЧДЫН БҮЖГИЙН СУРГАЛТЫН ТАЙЛАН

2019 оны 03 дугаар сарын 28

Улаанбаатар хот

2019 оны 3 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл сарын турш төвийн нийт багш, албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор венийн вальс бүжгийн сургалт явуулл



ТАЙЛАН БИЧСЭН
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Б.БАТГЭРЭЛ




МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН АЖИЛТАН АЖИЛЧДАД ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ, ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААР ЯВУУЛСАН СУРГАЛТЫН ТАЙЛАН

2019 оны 03 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Сүхбаатар Дүүргийн Гэр Бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газрын мэргэжилтэн н.Алтантүлхүүр, СБ Дүүргийн 6 хорооны Нийгмийн ажилтан Отгонзул нарыг урин ажилтан ажилчдадаа Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг, Жендерийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн талаар сургалтыг амжилттай зохион байгуулан ажиллалаа.

Сургалтыг асуулт, хариулт болон тоглоомын хэлбэрээр явууллаа. Нийт 35 хүн сургалтад хамрагдлаа.





ТАЙЛАН БИЧСЭН
НИЙГМИЙН АЖИЛТАН

Б.ЭНЦХЦЭЦЭГ

БАГШ АЖИЛЧДЫН ДУНД ЗОХИОН ЯВУУЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГАЛТЫН ТАЙЛАН


2019 оны 04 дүгээр сарын 12

Улаанбаатар хот

04 дүгээр сарын 12 ний өдрийн 15.00-16.00 цаг хүртэл Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн багш ажилчдын дунд СБ Дүүргийн 6 хорооны Сайн Наран өрхийн эмнэлэгийн нийгмийн ажилтан н.Цолмон, сувилагч Өлзий нар “Цусны даралт ихдэх өвчнөөс сэргийлэх, даралт бууруулах цэгэн иллэг хийх, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагтай зөвлөмж өгсөн. Мөн цэгэн иллэг хийх аргачлалыг биечлэн зааж нийт 26 хүн хамрагдсан. Хэрэгтэй зөвлөмж сургалтын гарын авлага тараасан. Ажилчид өөрсдийн сонирхсон асуултаа асууж хариултыг авч байлаа.



ХҮЯН ХӨӨРӨХ БА ТАРХИНЫ ЦУСАН ХАНГАМЖИЙН ДУТАГДАЛ



Тархийг тэжээлээр хангаж байдаг хууцны ар шилийг дагасан гол судас хатуурч нарийсах нь **ХҮЯН ХӨӨРӨХ** эмгэг шинжээр илрэх бөгөөд улмаар тархины цусан хангамжийн дутагдлын гол шалтгаан болдог. Энэхүү эмгэгийн үед тархи руу урсах цусны хэмжээ багассанаар тархины тараагуур хялгасан судаснууд (хохио) унаж улмаар мэдрэлийн үйл ажиллагаанууд алдагдан, цус харвалтын шалтгаан болно.



ТАЙЛАН БИЧСЭН
ЭРҮҮЛ МЭНДИЙН АРГА ЗҮЙЧ

Ж.ДЭЛГЭРСАЙХАН

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН БАГШ АЖИЛЧДАД ГАМШГААС
ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ТАЛААР ЯВУУЛСАН СУРГАЛТЫН ТАЙЛАН

2019 оны 03 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Онцгой байдлын Ерөнхий газраас хамтран нийслэлийн удирдах бүрэлдхүүнтэй 2019 оны 03 дугаар сарын 15 ний өдөр явуулсан сургалтад өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу төвийн багш, ажилчдад 2019 оны 03 дугаар сарын 20 ний өдөр 16:30-17:30 цагт анхан шатны Ц.Дуламсүрэн багшийн ангид дараах 4 чиглэлийн дагуу сургалт явууллаа.

1. Гамшгийн бэлэн байдлыг хангах шаардлага, үндэслэл газар хөдлөлтийн аюул өнөөгийн байдлын талаар
2. Ирэх 4 дүгээр сард нийслэл даяар явагдах бэлэн байдлын сургуулийн зорилго, ая хобогдол, төвийн бие бүрэлдхүүний оролцооны талаар
3. Төвийн мэргэжлийн ангийн бие бүрэлдхүүний бэлэн байдлын томилгооны тодотголыг уншиж танилцуулах
4. Хүн нэг бүрийн бэлэн байдлын үүргэвчинд байвал зохих 15 зүйлийн талаар нэг бүрчилсэн тайлбар хийж танилцуулан тараах материал бэлтгэн хүн нэг бүрд өгсөн.

Оролцсон бүрэлдхүүний ирцийг тусгайлан гаргаж хавсаргав.

СУРГАЛТ ЯВУУЛСАН:
АЖ АХУЙ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Б.ГАНБААТАР

